



ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Эрдмийн зөвлөл шинэчлэн байгуулах тухай

“Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 6330:2017 стандартын 10 дугаар зүйл, Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирлын “Төвийн бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай” 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геронтологийн үндэсний төвийн “Эрдмийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг I, “Эрдмийн зөвлөл”-ийн ажиллах журмыг II хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан Геронтологийн үндэсний төвийн захирлын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/14 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдмийн зөвлөлийн дарга /Д.Отгонбаатар/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Р.ХИШИГЖАРГАЛ

Геронтологийн үндэсний төвийн
ерөнхий захирлын 2019 оны 02 сарын
25 -ны өдрийн 108 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт

Эрдмийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн

Эрдмийн зөвлөлийн дарга: Д.Отгонбаатар АУ-ны доктор, проф

Нарийн бичгийн

дарга: Ш.Уранчимэг

Гишүүд:

Э.Баярмаа АУ-ны доктор, профессор

М.Мөнхзол АУ-ны доктор, профессор

О.Чимэдсүрэн АУ-ны доктор, профессор


З.Хишигсүрэн АУ-ны доктор, дэд проф

Р.Оюунханд АУ-ны доктор

Д.Гантуяа АУ-ны доктор

Д.Нарантуяа АУ-ны доктор

Геронтологийн төвийн ерөнхий захирлын
2019 оны 02 сарын 25 -ны өдрийн
4/08 Дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



Геронтологийн үндэсний төвийн
“Эрдмийн зөвлөл”-ийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол улсын засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 34 тоот тогтоол, Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017 стандарт, Боловсрол соёл, шинжлэх ухааны Сайдын 2007 оны 454 дугаар тушаалыг тус тус үндэслэн Геронтологийн үндэсний төв нь эрдмийн зөвлөлтэй байна.
- 1.2 Эрдмийн зөвлөл нь энэхүү журмын дагуу Монгол улсад Геронтологи, гериатрийн салбарыг хөгжүүлэх эрдэм судлалын ажлын чиг хандлагыг тодорхойлох, удирдан чиглүүлэх, зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөн ажиллана.
- 1.3 Монгол хүний хөгшрөлтийн шалтгаан, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ахмад настанд үзүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж хамтран судлах.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1 Эрдмийн зөвлөлийг эрдэмтэд, мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр Геронтологийн үндэсний төвийн захирлын тушаалаар байгуулна.
- 2.2 Геронтологийн үндэсний төвийн эрдмийн зөвлөл нь нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Бүрэлдэхүүнд Геронтологи, гериатрийн салбарыг төлөөлөхүйц эрдэмтэдийг багтаасан байна.
- 2.3 Геронтологийн үндэсний төвийн эрдмийн зөвлөлийг Эрдмийн зөвлөлийн дарга удирдна.
- 2.4 Геронтологийн үндэсний төвийн эрдмийн зөвлөл нь эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна. Эрдэмтэн нарийн бичгийн даргыг төвийн захирлын шийдвэрээр томилон ажиллуулна.

2.5 Геронтологийн үндэсний төвийн эрдмийн зөвлөлийн байнгын үйл ажиллагаа нь Эрдмийн зөвлөлийн хурал байна. Хурал гишүүдийн 50-аас дээш хувийн ирцтэй байж хүчин төгөлдөр байна.

2.6 Эрдмийн зөвлөлийн хурлыг хэлэлцэх асуудлаас хамааран хугацаа товлон хурлыг хийнэ.

2.7 Эрдмийн зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгоно. Урамшуулалын хэмжээг Геронтологийн үндэсний төвийн захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлэж олгоно.

Гурав: Эрдмийн зөвлөлийн баримтлах зарчим

3.1 Эрдмийн зөвлөлийн дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүд нь эрдэм шинжилгээний ажилтны үйл ажиллагааны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, эрүүл мэндийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана

3.2 Эрдмийн зөвлөл нь судалгааны арга зүй, сэдэв, сургалтын хөтөлбөрийг хэлэлцэж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан байна.

Дөрөв: Эрдмийн зөвлөлийн эрх үүрэг

4.1 Эрдмийн зөвлөлийн дарга нь эрдмийн зөвлөлийн хурлыг удирдан явуулна.

4.2 Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь хурлын төлөвлөгөөг боловсруулан эрдмийн зөвлөлийн хурлаар баталгаажуулан, хурлын товыг тогтоож, зарлан хуралдуулах, хурлын бус цагт эрдмийн зөвлөлийн дотоод ажлыг хариуцна.

4.3 Эрдмийн зөвлөл нь Насжилт, настны эмгэг судлал, настны нийгмийн асуудлын чиглэлээр баримтлах эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох

4.4 Геронтологийн үндэсний төвөөс хийгдэх эрдэм шинжилгээ судалгаа, туршилтын ажлын арга аргачлал, төсөл хөтөлбөрийг батлах, явцыг хэлэлцэж үнэлгээ дүгнэлт гаргах,

4.5 Эмчилгээ оношилгооны стандарт, эмнэл зүйн удирдамж боловсруулах, нэвтрүүлэх ажлыг хэлэлцэн үнэлгээ дүгнэлт гаргах

4.6 Эрдэм шинжилгээний хурлыг үндэсний болон олон улсын түвшинд зохион байгуулах

4.7 Төвийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах

4.8 Залуу эмч, судлаач, докторант, магистрант нарыг эрдмийн зөвлөлийн эрдэмтдийг дагалдуулан эрдэм шинжилгээ судалгааны ажилд дадлагажуулан сургах

4.9 Тус төвийн эрдэм шинжилгээ, судалгаа, практикт үнэтэй хувь нэмэр оруулж ажилласан гадаад, дотоодын судлаач эрдэмтэн мэргэжилтэнд ажлын үр дүнг хэлэлцэж “Хүндэт профессор” цол, гэрчилгээ олгож хүндэтгэл үзүүлэх.

_____xxxxxx_____